

Төлөөлөгчийн газраар дамжуулан элсэх хүсэлт гаргах

Монгол дахь Төлөөлөгчийн газраас шууд лавлана уу.

※Төлөөлөгчийн газар

<http://www.abk.ac.jp/монгол-хэл/>

Шууд сургуульд хандан хүсэлт гаргах



①Тус сургуулийн цахим хуудаснаас онлайнгаар элсэх хүсэлтийн маягт авах хүсэлтээ ирүүлнэ үү.

<http://www.abk.ac.jp/english/application/apply-now/>



Тус сургууль хүсэлтийг хүлээн авч, сургуульд элсэх хүсэлтийн маягт (excel)-ыг E-mail-ээр явуулна.



②Сургуульд элсэх хүсэлтийг бүрэн бөглөн, E-mail-ээр буцааж ирүүлнэ үү.

Тус сургууль элсэх хүсэлтийг хүлээн авч, хариуг нь E-mail-ээр мэдэгдэнэ.



③ E-mail-ээр хүлээн авсан хариугаа хэвлэж, гарын үсгээ зурна уу.



④ Шаардагдах бичиг баримтуудыг бүгдийг нь шуудангаар илгээнэ үү.

※Шуудангаар илгээсэн бичиг баримтууд, элсэх хүсэлт хүлээн авах хугацаанд амжиж Японд ирсэн байхаар зохицуулна уу.



Тус сургууль бичиг баримтуудыг хүлээн авсны дараа, хүлээн авснаа E-mail-ээр мэдэгдэх бөгөөд, хэрвээ бичиг баримтуудаа шуудангаар илгээснээс хойш 14 хоногийн дотор хүлээн авснаа мэдэгдэх E-mail очоогүй тохиолдолд бидэнтэй холбоо барина уу.

※Элсэх хүсэлт гаргах зааврын талаар асууж тодруулах зүйл гарвал биднээс чөлөөтэй асууж лавлана уу.

Элсэх хүсэлт гаргаснаас хойш Японд ирэх хүртэл

4-р сарын элсэлтийн оюутнууд	7-р сарын элсэлтийн оюутнууд	10-р сарын элсэлтийн оюутнууд	1-р сарын элсэлтийн оюутнууд	Тус сургууль	Элсэх хүсэлт гаргагч
9-10-р сар	12-2-р сар	3-4-р сар	6-8-р сар	Сургуульд элсэх хүсэлт хүлээн авах Хүсэлтийг хүлээн авснаа E-mail-ээр мэдэгдэх	Сургуульд элсэх хүсэлт гаргах, Элсэлтийн сонгон шалгаруулалтын хураамж төлөх
10-11-р сар	2-р сар	4-5-р сар	8-9-р сар	Элсэлтийн сонгон шалгаруулалт	
11-р сарын сүүлч	3-р сарын эхэн	6-р сарын эхэн	9-р сарын дундуур	Япон улсад оршин суух зөвшөөрөл авах хүсэлт гаргах Сонгон шалгаруулалтын хариуг мэдэгдэх	Элсэлтийн хураамж төлөх Хүссэн тохиолдолд, · Оюутны дотуур байранд орох хүсэлт гаргах
2-р сарын сүүлч	5-р сарын сүүлч	8-р сарын сүүлч	11-р сарын дундуур	(Гадаадын иргэдийн бүртгэлийн газар) Япон улсад оршин суух зөвшөөрөл олгох	
3-р сар	6-р сар	9-р сар	12-р сар	Япон улсад оршин суух зөвшөөрөл авах хүсэлтийн хариуг мэдэгдэх Япон улсад оршин суух зөвшөөрөл, Сургуульд элсэх зөвшөөрлийг шуудангаар илгээх	Сургалтын төлбөр төлөх Хүссэн тохиолдолд, · Япон хэлний түвшин тогтоох шалгалт өгөх хүсэлтийг орлон гүйцэтгүүлэх хүсэлт гаргах Гадаад паспорт гаргуулах / виз мэдүүлэх
4-р сарын эхэн	6-р сарын сүүлч	9-р сарын сүүлч	12-р сарын сүүлч		Японд ирэх
4-р сарын эхэн	6-р сарын сүүлч	9-р сарын сүүлч	1-р сарын эхэн		Ерөнхий зааварчилгаа, Анги хуваарилах тест



Бие даасан боловсролын байгууллага ABK коллеж

ABK коллеж, Япон хэлний сургалт
A B K C O L L E G E

12-12, Honkomagome 2-Chome, Bunkyo-ku, Tokyo 113-0021, Japan
TEL : (81-3)6912-0756 FAX : (81-3)6912-0757
E-mail : info@abk.ac.jp URL : www.abk.ac.jp

School bank name : Mizuho bank (Hongo Branch)
Account Name : ABK COLLEGE
Saving Account : 075-2908788
Swift Code : MHCBJPJT

Bank address : 3-43-4 Hongo, Bunkyo-ku, Tokyo, Japan
Bank TEL : (81-3)3812-3261



Элсэлтийн журам

Элсэх хүсэлт гаргах тухай

Бүртгүүлэгчдэд тавигдах шаардлага

- Япон улсаас өөр улсад 12 жилийн боловсрол эзэмшсэн байх, эсвэл 12 жил сураад төгсөхөөр товлогдсон байх.
- Тус сургуулийг төгссөнийхөө дараа, Их сургуулийн бакалаврын сургалт, эсвэл Мэргэжлийн сургуульд дэвшин суралцах хүсэлтэй тохиолдолд, Их сургууль болон Мэргэжлийн сургуульд элсэн орох үедээ 18 нас (төрсөн он сар өдрөөр тооцно) хүрсэн байх.
- Тус сургуулийг төгссөнийхөө дараа, Их сургуулийн магистр, докторын сургалтанд дэвшин суралцах хүсэлтэй тохиолдолд, Их сургуулийн магистр, докторын сургалтанд элсэн орох үедээ 22 нас (төрсөн он сар өдрөөр тооцно) хүрсэн байх.
- 1-р сарын элсэлт (1 жил 3 сарын курс)-энд бүртгүүлэх тохиолдолд, элсэх хүсэлт гаргах үедээ Япон хэлний түвшин тогтоох шалгалтын N5-аас дээш түвшний Япон хэлний мэдлэгтэй байх.

Элсэх хүсэлт хүлээн авах хугацаа

- 4-р сарын элсэлт (1 жилийн курс, 2 жилийн курс) Элсэлтийн өмнөх оны 9-р сарын 1 - 10-р сарын 31
 - 7-р сарын элсэлт (1 жил 9 сарын курс) Элсэлтийн өмнөх оны 12-р сарын 10 - Элсэлтийн оны 2-р сарын 10
 - 10-р сарын элсэлт (1 жил 6 сарын курс) Элсэлтийн оны 3-р сарын 1 - 4-р сарын 28
 - 1-р сарын элсэлт (1 жил 3 сарын курс) Элсэлтийн өмнөх оны 6-р сарын 10 - 8-р сарын 10
- ※ Бүртгүүлэгчдийн тоо олон байвал, товлосон хугацаанаасаа эрт хүсэлт хүлээн авах хугацааг дуусгах тохиолдол байдаг.
※ 1-р сард элсэх курсын хувьд, оюутны орон тоо гүйцсэн байвал, элсэлт явуулахгүй байх тохиолдол байдаг.

Бүрдүүлэх бичиг баримт

2-3-р хуудасны "Элсэх хүсэлт гаргагчтай холбогдох бичиг баримт", "Амьжиргааны зардал, сургалтын төлбөр зэргийг төлөх төлбөрийн чадварыг нотлох бичиг баримт"-ыг элсэх хүсэлт хүлээн авах хугацаанд багтаан хураалгана.

Элсэх хүсэлтийн маягтыг, Монгол дахь төлөөлөгчийн газраас авах, эсвэл тус сургуулийн цахим хаягаар нэвтэрч, онлайнгаар маягт авах хүсэлтээ ирүүлнэ үү. Онлайнгаар маягт авах хүсэлт ирүүлсэн хүмүүст тус сургуулиас E-mail-ээр элсэх хүсэлтийн маягтыг явуулна. Япон хэл болон англи хэлнээс өөр хэл дээр бичигдсэн бичиг баримтанд Япон хэлний орчуулгыг хавсаргана уу. Excel дээр маягт бөглөхөд хүндрэлтэй тохиолдолд, тус сургуульд мэдэгдэнэ үү.

Элсэх хүсэлт гаргах заавар

4-р хуудаснаас харна уу.

Бүртгэлийн хураамж

20,000 иен

Сургуульд элсэх хүсэлт гаргах үедээ, банкны шилжүүлэг, эсвэл кредит картаар бүртгэлийн хураамжийг төлнө үү. Төлбөр хийх аргын талаар, тус сургуулийн цахим хуудасны "Course fees" хэсгээс харна уу. (<http://www.abk.ac.jp/english/course-fees/>) Элсэх хүсэлт хүлээн авах хугацаанд багтаан, бүртгэлийн хураамжийг төлөөгүй, төлбөр нь орж ирээгүй тохиолдолд, тухайн хүсэлт цуцлагдсанд тооцогдох тохиолдол байна. Мөнгөний шилжүүлгийн шим тгэлийг шилжүүлэгч тал нь хариуцна.

Элсэх хүсэлт гаргахад анхаарах зүйл

Тус сургууль нь, бичиг баримтыг хүлээн авсны дараа, бүртгэлийн дугаар олгох ба цаашид холбоо барихдаа, уг бүртгэлийн дугаар болон хүсэлт гаргачийн овог нэрийг хэрэглэх болно.

Сонгон шалгаруулах арга

Хураалгасан бичиг баримтыг үндэслэн сонгон шалгаруулалт явуулна. Шаардлагатай тохиолдолд, ярилцлагын шалгалт авна.

Элсэлтийн сонгон шалгаруулалтын хариуг мэдэгдэх

- 4-р сарын элсэлт
Өмнөх оных нь 12-р сарын эхээр, E-mail-ээр мэдэгдэнэ.
- 10-р сарын элсэлт
Тухайн оны 6-р сарын дундуур, E-mail-ээр мэдэгдэнэ.
- 7-р сарын элсэлт
Тухайн оны 3-р сарын дундуур, E-mail-ээр мэдэгдэнэ.
- 1-р сарын элсэлт
Өмнөх оных нь 9-р сарын сүүлчээр, E-mail-ээр мэдэгдэнэ.

Элсэлтийн хураамж

80.000 иен

Элсэхээр зөвшөөрөгдсөн оюутнууд, заасан хугацаанд, банкны шилжүүлэг, эсвэл кредит картаар элсэлтийн хураамжийг төлнө үү. Төлбөр хийх аргын талаар, тус сургуулийн цахим хуудасны "Course fees" хэсгээс харна уу. (<http://www.abk.ac.jp/english/course-fees/>) Мөнгөний шилжүүлгийн шимтгэлийг шилжүүлэгч тал нь хариуцна.

Заасан хугацаанд элсэлтийн хураамжийг төлөөгүй, төлбөр нь орж ирээгүй тохиолдолд, автоматаар цуцлагдсанд тооцогдож, Гадаадын иргэдийн бүртгэлийн газарт гаргасан Япон улсад оршин суух зөвшөөрөл авах хүсэлтийг цуцлах тохиолдол байна.

Япон улсад оршин суух зөвшөөрөл гараагүй тохиолдлоос бусад тохиолдолд, элсэлтийн хураамжийг зарчмын хувьд буцааж олгохгүй.

Япон улсад оршин суух зөвшөөрөл авах хүсэлт

Тус сургуулийн элсэлтийн сонгон шалгаруулалтанд тэнцсэн оюутнуудад, тус сургуулийн зүгээс Токио дахь Гадаадын иргэдийн бүртгэлийн газарт "Япон улсад оршин суух зөвшөөрөл" авах хүсэлтийг гаргана. Энэхүү зөвшөөрөл нь, тус сургуулийн "Сургуульд элсэх зөвшөөрөл"-ийн хамт, оюутны виз мэдүүлэхэд шаардагдах бичиг баримт болно.

Сургалтын төлбөр

Сургалтын төлбөрийн эхний хэсэг

- 4 болон 10-р сарын элсэлт ... 310.000 иен (Хагас жилийн төлбөр)
 - 7 болон 1-р сарын элсэлт ... 465.000 иен (9 сарын төлбөр)
- Сургалтын төлбөрт сургалтын материал, байгууламжийн ашиглалт, хичээлээс гадуурх үйл ажиллагааны зардал болон даатгалын шимтгэл (Япон хэлний сургуулийн оюутнуудад зориулсан гамшгийн даатгалын тогтолцоо) орсон болно.

Дээрх төлбөр нь, сургалтын төлбөрийн эхний хэсэг нь болох ба, дараагийн төлбөрөөс эхлэн, хагас жил тутамд 310.000 иен төлнө.

Япон улсад оршин суух зөвшөөрөл гарсан талаар мэдэгдэл хүлээн авсан оюутнууд, заасан хугацаанд, заасан банкны дансанд, сургалтын төлбөрийг төлнө үү. Төлбөр хийх аргын талаар, тус сургуулийн цахим хуудасны "Course fees" хэсгээс харна уу. (<http://www.abk.ac.jp/english/course-fees/>) Мөнгөн ий шилжүүлгийн шимтгэлийг шилжүүлэгч тал нь хариуцна. Заасан хугацаанд сургалтын төлбөрийг төлөөгүй, төлбөр нь орж ирээгүй тохиолдолд, автоматаар цуцлагдсанд тооцогдож, Сургуульд элсэх зөвшөөрлийг хүчингүй болгох тохиолдол байна. Сургалтын төлбөрийг буцаан олгох талаар 3-р хуудаснаас харна уу.

Бүрдүүлэх бичиг баримт

*тэмдэгтэй бичиг баримтын маягыг, Монгол дахь төлөөлөгчийн газраас авах, эсвэл тус сургуулийн цахим хаягаар нэвтэрч, онлайнар маягт авах хүсэлт тээ ирүүлнэ үү.

Элсэх хүсэлт гаргагчтай холбогдох бичиг баримт (1-9 хүртэлх бичиг баримтыг заавал хураалгана.)

- | | |
|---|---|
| <p>1 Сургуульд элсэх хүсэлт*</p> <p>2 Сургуульд элсэх шалтгаан*
Эх хэл, эсвэл англи хэл дээр бичнэ.</p> <p>3 Гадаадад суралцах зөвшөөрөл*</p> <p>4 Санал асуулга*</p> <p>5 Бүрэн дунд боловсролын гэрчилгээ, эсвэл их сургуулийн диплом
Хуулбар болохгүй. Нотариатаар батлуулсан хуулбар болно.
Сурч буй тохиолдолд, төгсөхөөр товлогдсон он сар өдрийг тодорхой бичсэн "Төгсөх товын тодорхойлолт"-ыг хураалгаж, төгссөн даруйдаа гэрчилгээ / дипломоо хураалгах.
Хамгийн сүүлд суралцсан сургуулиа дундаас нь орхисон тохиолдолд, "Сурч байсныг гэрчлэх тодорхойлолт", эсвэл "Дундаас нь орхисныг гэрчлэх тодорхойлолт"-ыг хураалгах.</p> <p>6 Ахлах ангийн, эсвэл их сургуулийн хичээлийн жил тус бүрийн дүнгийн тодорхойлолт
Хуулбар болохгүй. Нотариатаар батлуулсан хуулбар болно.
Улсын шалгалт өгч байсан бол, дүнгийнх нь хуулбарыг мөн хураалгах.</p> | <p>7 Гадаад паспортын хуулбар
Гадаад паспорттой бол, хуулбарыг нь хураалгах. Өмнө нь Японд ирж байсан тохиолдолд, Япон улсад орж, гарсан тамгатай хуудаснуудын хуулбарыг мөн хураалгах.</p> <p>8 6 хувь цээж зураг
3 см x 4 см хэмжээтэй, цээжин биеийн, эгц урдаас нь авсан, сүүлийн 3 сард авахуулсан зураг.
Зурагнаахад ар талд нь иргэншил болон овог нэрээ бичсэн байх.</p> <p>9 Эрүүл мэндийн үзлэгт орсон бичиг*
Тус сургуулиас заасан зориулалтын маягыг эмчээр бөглүүлж, гарын үсэг зуруулах.</p> <p>※Дараах бичиг баримтыг зөвхөн хамаарах хүмүүс хураалгана уу.</p> <p>10 Японд сурч байсан сургуулийн ирцийн тодорхойлолт болон дүнгийн тодорхойлолт
Японд сурч байсан хүмүүс.</p> <p>11 Японд амьдардаг төрөл садны оршин суугчийн карт буюу "Зайрю карт" (гадаадын иргэний бүртгэлийн үнэмлэх)-ны хуулбар ар өвөргүй, эсвэл оршин суугаа газрын захиргааны бүртгэлийн бичиг буюу "Жюүмин-хио"
Японд амьдардаг төрөл садантай хүмүүс.</p> |
|---|---|

А: Япон улсаас өөр улсад оршин суугаа төрөл садан нь амьжиргааны зардал, сургалтын төлбөр зэргийг төлөх тохиолдолд, дараах бичиг баримт ыг хураалгана уу. Үүнд:

- | | |
|--|---|
| <p>1 Зардлыг батлан даах бичиг*
Зардлыг батлан даагч нь өөрөө уг бичгийг үйлдсэн он сар өдрийг бичиж, гарын үсгээ зурах. Амьжиргааны зардлыг бичих хэсэгт, тухайн оюутны амьжиргааных нь зардалд зориулан явуулахаар төлөвлөж буй мөнгөн дүнгийнхээ сарын дундаж хэмжээг бичнэ.</p> | <p>3 Зардлыг батлан даагчийн ажлын газрын тодорхойлолт (а., б.-гийн аль нэгийг нь хураалгах)
а. Компаний ажилтан бол, компаниасаа "Ажлын газрын тодорхойлолт" гаргуулж хураалгах.
б. Компаний захирал болон хувийн бизнес эрхлэгч бол, тухайн компаний "Улсын бүртгэлийн гэрчилгээ", "Үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл" зэрэг зардлыг батлан даагчийн нэр болон компаний нэр нь тодорхой бичигдсэн бичиг.</p> |
| <p>2 Зардлыг батлан даагчийн дансны үлдэгдлийн тодорхойлолт
Дансан дахь үлдэгдэл мөнгөн дүн болон он сар өдөр тодорхой бичигдсэн, банкны санхүү хариуцсан ажилтны гарын үсэг, тамгатай байх.
Компаний нэр дээрх дансны тодорхойлолт болохгүй.</p> | <p>4 Зардлыг батлан даагч болон элсэх хүсэлт гаргагч хоёрын төрөл садны хамаарлыг нотлох тодорхойлолт
Гэр бүлийн бүртгэлийн бичиг, эсвэл төрсний гэрчилгээ гэх зэрэг зардлыг батлан даагч болон элсэх хүсэлт гаргагч хоёрын хоорондын хамаарлыг нотлох бичиг.</p> |
| | <p>5 Зардлыг батлан даагчийн жилийн орлогын тодорхойлолт
Зардлыг батлан даагчийн хувь хүний жилийн орлого нь бичигдсэн "Татвар төлсөн тодорхойлолт", эсвэл компаниасаа гаргуулсан тодорхойлолт. (Зардлыг батлан даагчийн хувь хүний жилийн орлого нь бичигдсэн байх.)</p> |

В: Япон улсад оршин суугаа төрөл садан нь амьжиргааны зардал, сургалтын төлбөр зэргийг төлөх тохиолдолд, дараах бичиг баримтыг хураалгана уу. Үүнд:

- | | |
|--|--|
| <p>1 Зардлыг батлан даах бичиг*
Зардлыг батлан даагч нь өөрөө уг бичгийг үйлдсэн он сар өдрийг бичиж, гарын үсгээ зурах. Амьжиргааны зардлыг бичих хэсэгт, тухайн оюутны амьжиргааных нь зардалд зориулан явуулахаар төлөвлөж буй мөнгөн дүнгийнхээ сарын дундаж хэмжээг бичнэ.</p> | <p>5 Зардлыг батлан даагчийн ажлын газрын тодорхойлолт (а., б., с.-гийн аль нэгийг нь хураалгах)
а. Компаний ажилтан бол, компаниасаа "Ажлын газрын тодорхойлолт" гаргуулж хураалгах.
б. Компаний захирал бол, тухайн компаний "Улсын бүртгэлийн гэрчилгээ" болон "Ажлын газрын тодорхойлолт"
с. Хувийн бизнес эрхлэгч бол, Татварын газрын хүлээн авсан тамга бүхий "Татвар мэдүүлсэн баримт" буюу "Какүтэй шинкоүшо"-гийн хуулбар (дараа нь буцааж өгнө) болон өөрөө бичсэн "Ажлын газрын тодорхойлолт"</p> |
| <p>2 Зардлыг батлан даагчийн дансны үлдэгдлийн тодорхойлолт</p> | <p>6 Зардлыг батлан даагчийн жилийн орлогын тодорхойлолт
Хот / дүүрэг / тосгоны захиргаанаас авах "Татвар ноогдуулсан тодорхойлолт" буюу "Казэй шоомэйшо" (жилийн орлого нь бичигдсэн байх)</p> |
| <p>3 Оршин суугаа газрын захиргааны бүртгэлийн бичиг буюу "Жюүм ин-хио"
Өрхийн бүх гишүүдийн мэдээлэл бичигдсэн байх.</p> | |
| <p>4 Зардлыг батлан даагч болон элсэх хүсэлт гаргагч хоёрын төрөл садны хамаарлыг нотлох тодорхойлолт
Гэр бүлийн бүртгэлийн бичиг, эсвэл төрсний гэрчилгээ гэх зэрэг зардлыг батлан даагч болон элсэх хүсэлт гаргагч хоёрын хоорондын хамаарлыг нотлох бичиг.</p> | |

С: Элсэх хүсэлт гаргагч нь өөрөө зардлаа даах тохиолдолд, дараах бичиг баримтыг хураалгана уу. Үүнд:

- | | |
|---|--|
| <p>1 Зардлыг батлан даах бичиг*
Хүсэлт гаргагч нь өөрөө бүгдийг нь бичих. Сургалтын зардлыг бичих хэсэгт 310.000 иен, амьжиргааны зардлыг бичих хэсэгт, өөрийнхөө амьжиргааны зардалд зарцуулахаар бэлтгэх мөнгөн дүнгийнхээ сарын дундаж хэмжээг бичнэ.</p> | <p>3 Хүсэлт гаргагчийн ажлын газрын тодорхойлолт</p> |
| <p>2 Хүсэлт гаргагчийн дансны үлдэгдлийн тодорхойлолт
Дансан дахь үлдэгдэл мөнгөн дүн болон он сар өдөр тодорхой бичигдсэн, банкны санхүү хариуцсан ажилтны гарын үсэг, тамгатай байх.</p> | <p>4 Хүсэлт гаргагчийн жилийн орлогын тодорхойлолт
Хүсэлт гаргагчийн хувь хүний жилийн орлого нь бичигдсэн "Татвар төлсөн тодорхойлолт", эсвэл компаниас гаргуулсан тодорхойлолт. (Хүсэлт гаргагчийн хувь хүний жилийн орлого нь бичигдсэн байх.)</p> |

Бусад анхаарах зүйлс:

Хүчингүй болох бичиг баримт: Элсэх хүсэлт гаргахад шаардагдах бичиг баримтыг, Токио дахь Гадаадын иргэдийн бүртгэлийн газарт мөн хураалгадаг тул, дараах тохиолдолд уг бичиг баримт нь хүчингүй болно. Үүнд:
Бичиг баримтыг гаргуулсан өдөр (эсвэл бичсэн өдөр) нь, Гадаадын иргэдийн бүртгэлийн газарт хураалгах өдрөөс 3 буюу түүнээс дээш сарын хугацааны өмнөх бичиг баримт. Гадаадын иргэдийн бүртгэлийн газарт хураалгах өдөр: 4-р сарын элсэлт нь 11-р сарын сүүл үе, 7-р сарын элсэлт нь 3-р сарын эхэн үе, 10-р сарын элсэлт нь 6-р сарын эхэн үе, 1-р сарын элсэлт нь 9-р сарын дундуур.
Үйлдсэн он сар өдөр, үйлдсэн хүний гарын үсэггүй бичиг баримт.
Үг үсгийн алдааг штрихээр зассан бичиг баримт.

Япон улсад оршин суух зөвшөөрөл гараагүй тохиолдолд: Токио дахь Гадаадын иргэдийн бүртгэлийн газарт хянан шалгасны дүнд, оршин суух зөвшөөрөл гарахгүй байх тохиолдол байдаг. Энэ тохиолдолд, хүссэн үедээ Японд ирэх боломжгүй болно. "Оршин суух зөвшөөрөл гараагүй тухай мэдэгдэл"-ийг хүлээн авбал, дараагийн элсэлтэнд дахин элсэх хүсэлт гаргах (дараагийн элсэлтийн бүртгэлийн хураамж болон элсэлтийн хураамжийг төлөх шаардлагагүй), эсвэл элсэлтээ цуцлах талаар тус сургууль руу холбоо барьж мэдэгдэх хэрэгтэй. Элсэлтээ цуцлах тохиолдолд, элсэлтийн хураамжийг буцаан олгох тул, шилжүүлэх дансны дугаар зэрэг мэдээллээ тус сургуулийн заасан маягтанд бөглөж, тус сургууль руу явуулах.

Сургалтын төлбөрийг буцаан олгох тухай

Сургалтын төлбөрийг буцааж олгохгүй. Гагцхүү, дараах тохиолдлуудын аль нэгэнд нь тохирох бөгөөд, элсэх хүсэлт гаргагч нь хүсэлт гаргаж, тогтсон нөхцөлд гүйцээсэн тохиолдолд, сургалтын төлбөрийг буцаан олгоно.

- (1) Японы виз гараагүй тохиолдол бөгөөд, төлбөрийг буцаан олгоход шаардагдах бичиг баримт болох "Сургуульд элсэх зөвшөөрөл", "Төлбөрийг буцаан авах нэхэмжлэл", гадаад паспортын хуулбарыг тус сургуульд хураалгасан тохиолдол.
- (2) Элсэлтийн ёслол болохоос өмнө элсэлтээ цуцалсан бөгөөд, Японд ирэлгүйгээр, төлбөрийг буцаан олгоход шаардагдах бичиг баримт болох "Япон улсад оршин суух зөвшөөрөл", эсвэл "Визийг хүчингүй болгосон паспортын хуулбар", "Сургуульд элсэх зөвшөөрөл", "Элсэлтийг цуцлах шалтгааныг бичсэн бичиг", "Төлбөрийг буцаан авах нэхэмжлэл"-ийг тус сургуульд хураалгасан тохиолдол.